

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХЭЛТСИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ГАНБАТЫН ДАЛАЙЦЭРЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
Зорилт 1. “ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ, БОДЛОГО, СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1.	Арга хэмжээ 1.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэхэд.	Үйлчилгээний тоо	1,033	1,200	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д Албан журмын даатгагчдын холбооноос жолоочийн хариуцлагын цахим даатгалын үйлчилгээ, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-аас хөнгөлөлттэй үнээр авто зам ашигласны төлбөрийг төлөх хүсэлт хүлээн авах үйлчилгээ, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын газраас Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын нийлбэр хувийн тунгийн лавлагаа, Цацрагийн үүсгүүрийн жилийн эцсийн бүртгэл тооллого, дотоод хяналтын тайлан, Цацрагийн үүсгүүр хүлээн авсан тухай мэдэгдэл, Цацрагийн хяналтын ажилтан солигдсон талаарх мэдэгдэл, Байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм гэх нийт 5 үйлчилгээг тус тус нэвтрүүлэх хүсэлтийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт судалж, шийдвэрлүүлэхээр хүргүүлж ажилласан. Мөн 2024 оны 12 дугаар сарын сүүлийн байдлаар байдлаар 87 байгууллагын 1263 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-ээр дамжуулан 61,925,064 удаа амжилттай цахим хэлбэрээр үзүүлж байна.		2024.01.10 - 2024.12.05	100%
	Дэд арга хэмжээ 1.1.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-	Нэгтгэсэн тайлангийн тоо	-	1	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-ын статистик мэдээллийг “И Монгол Академи		2024.01.10 - 2024.12.15	100%

	mongolia)-ийн үйлчилгээний нэмэгдүүлсэн нэгтгэх.	тоог тайлан			УТҮГ"-аас 7 хоног бүр цахим хэлбэрээр хүлээн авч нэгтгэн ажилласан.		
2.	Арга хэмжээ 1.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ.	Хэрэглэгчийн тоо	1,738,939	1,838,939	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д нэвтэрсэн "Эмийн жор", "Шинжилгээний хариу", "Дүрс оношилгооны дүгнэлт", "Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ", "Амбулаториор эмчлүүлэгчдийн карт", "Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч карт", "Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" буюу нийт 7 үйлчилгээг олон нийтэд сурталчлах контент бэлтгэх, түгээх ажлыг "Их хөгжлийн урсгал" НҮТББ-аар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цахим ур чадвар олгох контент боловсруулах ажлыг Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүний телевизийн "Тулга тавилан" студи НҮТББ-аар тус тус гүйцэтгүүлж иргэд, олон нийтэд түгээсэн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын байдлаар 1,940,919 буюу насанд хүрсэн иргэдийн 78% нь төрийн үйлчилгээний нэгдсэн системд бүртгүүлсэн байна.	2024.01.10 - 2024.12.15	100%
	Дэд арга хэмжээ 1.2.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ийн хэрэглэгчийн тоог нэмэгдүүлсэн тайлан нэгтгэх.	Нэгтгэсэн тайлангийн тоо	-	1	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-ын статистик мэдээллийг "И Монгол Академи УТҮГ"-аас 7 хоног бүр цахим хэлбэрээр хүлээн авч нэгтгэн ажилласан.	2024.01.10 - 2024.12.15	100%
Зорилт 2. "ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ОНОВЧТОЙ БОЛГОХ, ТЕХНОЛОГИ-ИННОВАЦ НЭВТРҮҮЛЭХ"							
1.	Арга хэмжээ 2.1. Төрийн үйлчилгээний 24/7 "ХУРДАН" цэгийг байгуулна.	24/7 "ХУРДАН" цэгийн тоо	-	2	Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р багт 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, Орхон аймагт 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 2024 оны 8 дугаар сарын 10-ны өдөр, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Дархан Өртөө-1 галт тэрэгний буудалд 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдөр тус тус 1 буюу нийт 5 Төрийн үйлчилгээний 24/7 "ХУРДАН" цэг байгуулагдсан.	2024.01.10 - 2024.12.05	100%

2.	Арга хэмжээ 2.2. Төрийн үйлчилгээний хөдөлгөөнт "ХУРДАН" цэгийг байгуулна.	Хөдөлгөөнт "ХУРДАН" цэгийн тоо	1	10	Улаанбаатар хот, Хэнтий аймагт тус тус 1 Төрийн үйлчилгээний хөдөлгөөнт "ХУРДАН" цэг байгуулагдсан бөгөөд 20 аймагт шинээр байгуулахаар ажиллаж байна.	2024.01.10 - 2024.12.05	60%
Зорилт 3. "ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЯЛДАА ХОЛБОО, НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ"							
1.	Арга хэмжээ 3.1. Монгол Улсын байнгын ажиллагаатай хилийн боомт, гадаад улсад суугаа элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, бусад байршилд төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг нээнэ.	"ХУРДАН"цэгийн тоо	22	27	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын салбар Төрийн үйлчилгээний ХУРДАН цэгийг 1.БНХАУ-ЫН Манжуур хот дахь Консулын газар; 2.БНХАУ-ЫН Эрээн хотод суугаа Консулын газар; 3.ӨМӨЗО-ы Хөххот дахь Ерөнхий Консулын газар; 4.БНБУ-д суугаа ЭСЯ; 5.ОХУ-ын Эрхүү хот дахь Ерөнхий Консулын газар; 6.ОХУ-ын Улаан Үд хот дахь Ерөнхий Консулын газар; 7.ОХУ-д суугаа ЭСЯ; 8. ОХУ-ын Кызыл хот дахь Ерөнхий консулын газар; 9.Кувейт Улсад суугаа ЭСЯ; 10.БНАЛУ-д суугаа ЭСЯ; 11.АНУ-д суугаа ЭСЯ; 12.АНУ-ын Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын Төлөөлөгчийн газар; 13.АНУ-ын Сан Франциско хот дахь Ерөнхий Консулын газар; 14.АНУ-ын Чикаго хот дахь Консулын газар; 15.Швейцарийн Холбооны Улсын Женев дэх Монгол Улсын ЭСЯ; 16.Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа ЭСЯ; 17.Казахстан Улсын Алматы хот дахь Консулын төлөөлөгчийн газар; 18.Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа ЭСЯ; 19.Бүгд Найрамдах Польш Улсад суугаа ЭСЯ; 20.Канад Улсад суугаа ЭСЯ; 21.ИБУИНХУ-д суугаа ЭСЯ; 22.БН Итали Улсад суугаа ЭСЯ; 23.БН Египет Улсад суугаа ЭСЯ; 24.БН Киргиз Улсад суугаа ЭСЯ; 25.БН Беларусь Улсад суугаа ЭСЯ буюу 2024 онд 25 цэгийн үйл ажиллагааг хилийн чанадад нээж, нийт 31 улсын 47 цэг, хилийн боомтод 1 цэгийн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.	2024.01.10 - 2024.06.18	100%
2.	Арга хэмжээ 3.2. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг албан ёсны цахим хуудаст байршуулсан эсэхэд үнэлгээ хийнэ.	Үнэлгээний тоо	135	168	"Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар ашиглалтад нэвтрүүлсэнтэй холбогдуулан шинээр 33 байгууллагыг үнэлээд байна. www.shilen.gov.mn	2024.01.10 - 2024.12.05	100%

4.	Арга хэмжээ 3.3. Төрийн үйлчилгээний операторын системийн 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ.	Нэвтрүүлсэн хувилбар	1.0 хувилбар	2.0 хувилбар	Хүн хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд системийн тасалдал, саатал, хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх, сайжруулахад зорилгын хүрээнд операторын системийн UI/UX дизайныг хэрэглэгчид ойлгомжтой, хялбар, гацалтгүй, хянах самбартай байхаар 2.0 хувилбарыг хөгжүүлж, ашиглалтад оруулсан. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (Оператор)-ийг хөгжүүлэх, алдаа доголдлыг засаж сайжруулах ажлын төлөвлөгөөг 2024 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	2024.01.10 - 2024.12.05	100%
	Дэд арга хэмжээ 3.3.1. Төрийн үйлчилгээний операторын системийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлуулах.	Батлуулсан төлөвлөгөөний тоо	-	1	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг хөгжүүлэх, алдаа доголдлыг засаж сайжруулах төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр боловсруулж, тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	2024.01.10 - 2024.02.13	100%
	Дэд арга хэмжээ 3.3.2. Холбогдох байгууллагаас төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн хэрэгжилтийн тайлан нэгтгэх.	Нэгтгэсэн тайлангийн тоо	-	1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 01/275 дугаар албан бичгээр Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг хөгжүүлэх алдаа доголдлыг сайжруулах ажлын тайланг ирүүлснийг нэгтгэсэн.	2024.01.10 - 2024.08.16	100%
Зорилт 4. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”							
1.	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана.	Батлагдсан төлөвлөгөөний тоо	-	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулсан.	2024.01.10 - 2024.01-10	100%
		Тайлангийн тоо	-	2	Төрийн жинхэнэ албан хаагчийн эхний хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж, тайлагнасан.	2024.01.10 - 2024.12.05	100%

2.	Арга хэмжээ 4.2. Хариуцсан чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Хариуцсан чиглэлээр холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн байна	-	Хэрэгжилтээр	Төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн	2024.01.10 - 2024.12.05	100%
3.	Арга хэмжээ 4.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	-	Хэрэгжилтээр	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийн хэрэгжилт болон хугацаа болоогүй.	2024.01.10 - 2024.12.05	-
4.	Арга хэмжээ 4.4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	-	Хэрэгжилтээр	Иргэн Н.Мөнгөн-Эрдэнээс ирүүлсэн "Төрийн байгууллагуудын цахим хуудсыг нэгэн ижил загварт оруулах тухай" саналыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын тушаалаар 2024 оны урсгал төсвийн худалдан авах төлөвлөгөөг баталсан. Дээрх төлөвлөгөөний дагуу "Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас хөгжүүлэх" тендер зарлахаар төлөвлөж байна. Тус тендерийг гүйцэтгүүлснээр Төрийн байгууллагын цахим хуудасны загвар ижил болж, бүх мэдээллийг нэгдсэн нэг цахим хуудаснаас авах боломж бүрдэнэ гэж хариуг хүргүүлж шийдвэрлэсэн,	2024.01.10 - 2024.12.05	100%

				Мөн Г.Нарантуяагаас ирүүлсэн “Монгол хэлний алдаа шалгуурын программ (spellcheck.mn) алдаатай засварлаж буй тухай” гомдлын хариуг “Болорсофт” ХХК-ний хариуцан ажилладаг дүрмийн алдаа хянагч программ нь Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-д заасны дагуу дүрмийн алдааг хянан ажилладаг. Иймд та гомдолтой холбоотой дэлгэрэнгүй тайлбарыг тухайн хариуцагч байгууллага эсхүл монгол хэлний дүрэм тайлбарлах чиг үүрэг бүхий байгууллагаас тодруулна уу гэж 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн. Иргэн Б.Батняаас ирүүлсэн “дүрмийн алдаа хянагч программ Spellcheck.com ажиллахгүй байгаа тухай” гомдолтой танилцаад дараах хариуг хүргүүлсэн. 1.Дүрмийн алдаа хянагч программ (spellcheck.gov.mn)-ын ажиллагаа хэвийн болсон. 2.(spellcheck.mn) болон (spellcheck.gov.mn) цахим хуудаснууд нь алдааг ижил өгөгдлийн сангаас татаж ажилладаг тул өөрийн сонголтоор ашиглах боломжтой. 3.Дээрх дүрмийн алдаа хянагч программыг "Болорсофт" ХХК хариуцан ажилладаг бөгөөд тус программтай холбоотой асуудлыг хариуцагч байгууллагаас тодруулах, мөн дүрмийн алдаатай холбоотой асуудлыг хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагаас тодруулна уу. Иргэн Ш.Оюунчимэгээс ирүүлсэн “Шүүх, цагдаа, эрүүл мэндийн салбарыг цахимжуулах тухай” саналтай танилцаад дараах хариуг хүргүүлсэн. Тус яам болон Цагдаагийн ерөнхий газар хамтран ажлын хэсэг байгуулж Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх талаар дахин загварчлал хийхээр төлөвлөөд байна. Мөн Шүүх шинжилгээний ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газартай холбоотой гомдол саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд эсхүл тухайн	
--	--	--	--	--	--

					байгууллагад өргөдөл, гомдол, санал гаргах нь зүйтэй. Монгол Улсын прокурорын ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын дээд шүүх, тус өргөдөлтэй холбогдох шүүхийн байгууллагатай өргөдөл, гомдол, санал гаргах тохиолдолд харьяалах дээд байгууллагад хандах нь зүйтэй болно.		
5.	Арга хэмжээ 4.5. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж, ажилласан баримтын тоо	-	1	Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр мэдүүлсэн. Мөн тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг тус тус хугацаанд нь мэдүүлж, баталгааны маягтыг баталгаажуулж Захиргааны эрх зүйн асуудал хариуцсан шинжээч (Б.Солонго)-д хүргүүлсэн.	2024.01.10 - 2024.01.10	100%
6.	Арга хэмжээ 4.6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Өгсөн үүрэг даалгаврын тоо	-	Хэрэгжилтээр	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай, бүрэн гүйцэтгэж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	2024.01.10 - 2024.12.05	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллах			Худалдан авах ажиллагааны үр дүн хүргүүлсэн байна.	1.Монгол Улсад бүртгэлтэй, эмчийн жороор олгодог эмийн хэрэглээ, зааварчилгааг цахим видео хэлбэрээр (AR) төрийн цахим үйлчилгээний eMongolia системээр танилцах боломжийг бүрдүүлэх (ЦХХХЯ/20240103024) дугаартай тендерийг Тус яаманд "Эй Ар Монголиа" ХХК-ийн 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн "Хамтран ажиллах тухай" А/015 дугаар албан бичгийн дагуу төлбөргүй гүйцэтгүүлэн хүлээн авсан. 2.Мөн Төрийн үйлчилгээний операторын системийг хөгжүүлэх (ЦХХХЯ/20240103035) дугаартай тендертэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргаар 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Үндэсний дата төв УТҮГ, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон И Монгол Академи УТҮГ нар хариуцан Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг хөгжүүлэх, алдаа доголдлыг засаж сайжруулах ажлын төлөвлөгөөг батлуулсан. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах контент боловсруулах ЦХХХЯ/20240203038 дугаартай 70,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг харьцуулалтын аргаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт зарлаж, Тэнгис пикчерс ХХК (64,800,000 төгрөг) болон Гэрэгэ дижитал технологи ХХК (56,000,000 төгрөг) буюу нийт 2 оролцогчтой 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10:30 цагт нээсэн. 3.Тендерт оролцогчдыг үнэлгээний хороо хянан үзэхэд бүх оролцогчид Татварын төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан ерөнхий шаардлагыг хангахгүй тул бүх тендерээс татгалзах тухай мэдэгдлийг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр оролцогчдод хүргүүлсэн. Тус тендерт оролцогч	2024.01.19-2024.12.05	100%

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					“Гэрэгэ дижитал технологи” ХХК-аас захиалагчийн татгалзсан шийдвэрийг хянан үзэхийг хүссэн гомдол гаргасны дагуу Сангийн яам хянан үзэж “Гэрэгэ дижитал технологи” ХХК-ийн аж ахуй нэгжийн орлогийн албан татварын 698,572.29 төгрөгийн дутуу үлдэгдэл нь хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан хугацаа хэтэрсэн өр эсэхийг Татварын ерөнхий газраас тодруулж, үнэлгээ хийх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Иймд дээрх Сангийн яамны шийдвэрийн дагуу Татварын ерөнхий газраас тодруулахад “Тэнгис пикчерс” ХХК татварын өргүй, “Гэрэгэ дижитал технологи” ХХК 698,572.29 төгрөгийн татварын өртэй гэж ирүүлснийг үндэслэж үнэлгээний хороо хуралдан үнэлэхэд “Гэрэгэ дижитал технологи” ХХК хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан ерөнхий шаардлагыг хангаагүй, “Тэнгис пикчерс” ХХК тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан тул хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчоор “Тэнгис пикчерс” ХХК-г сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн. Шалгарсан байгууллагатай Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах контент боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн ЦХХХЯ/20240203038 дугаар гэрээг байгуулж, ажлын даалгаварт заасан ажлыг бүрэн гүйцэтгүүлэн 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж, цуврал 2 ширхэг контент хүлээн авсан. 4.Залуучуудад зориулсан дижитал ажлын байрыг бий болгох хөтөлбөр боловсруулах ЦХХХЯ/20240103027 дугаартай 300,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 10:00 цагт зарлаж, “Гөү лаб” ХХК (298,700,000 төгрөг), “ЭМПАТТС”		

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					ХХК (300,000,000 төгрөг), “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨААТҮГ (300,000,000 төгрөг) буюу нийт 3 оролцогчтойгоор 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр нээсэн. Тендерт оролцогчдыг үнэлгээний хороо хянан үзэхэд бүх оролцогчид тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан тул төсөвт өртөгт багтаан 298,700,000 төгрөг буюу тендер шалгаруулалтад хамгийн бага үнийн дүн бүхий тендер ирүүлсэн оролцогч болох Гөү лаб ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн. Шалгарсан байгууллагатай Залуучуудад зориулсан дижитал ажлын байрыг бий болгох хөтөлбөр боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ЦХХХЯ/20240103027 дугаар гэрээг байгуулсан бөгөөд гүйцэтгэгч байгууллагаас 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр гэрээ сунгуулах тухай хүсэлт ирүүлсний дагуу 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж, хөтөлбөрт хамрагдсан нийт оролцогчдын 27.1% буюу 95 оролцогчдоос ирүүлсэн “Ажлын ачаалал, хэт шахуу хөтөлбөр, ар гэрийн асуудал, англи хэлний түвшин гэх мэт” хүсэлтийг үндэслэн 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд сунгахаар шийдвэрлэн нэмэлт гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллага гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгэж тайланг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн бөгөөд гэрээ дүгнэсэн акт үйлдэж, ажлыг хүлээн авсан. 5.Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас хөгжүүлэх ЦХХХЯ/20240103037 дугаартай 200,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарлаж, “Аствишн” ХХК (200,000,000 төгрөг), “Эверест солюшн” ХХК (189,807,750 төгрөг) буюу нийт 2 оролцогчтойгоор		

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 15:30 цагт нээсэн. Тендерт оролцогчдыг үнэлгээний хороо хянан үзэхэд “Эверест солюшн” ХХК тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаж, “Аствишн” ХХК-ний ирүүлсэн материал тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хүний нөөцийн чадавхыг хангаагүй тул “Эверест солюшн” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр хүргүүлсэн. Тус тендерт оролцогч “Аствишн” ХХК-аас “Эверест солюшн” ХХК-ийн санал болгосон багийн ахлагч нь мастер болон түүнээс дээш зэрэг эзэмшсэн, мэдээлэл технологийн чиглэлээр 20 жил ажилласан туршлагатай болох нотлох баримт ирүүлээгүй, хөгжүүлсэн e-invest.mn цахим хуудас англи, монгол хэлээр нийтлэх боломжтой цахим хуудас хөгжүүлж, нэвтрүүлсэн байх туршлагын шаардлага хангаагүй, худалдан авах ажиллагааны цахим системээр хүний нөөцийн мэдээллийг бөглөж санал болгоогүй нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасныг хангаагүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэх гомдлын дагуу Сангийн яам хянан үзэж гомдолд дурдсан e-invest.mn цахим хуудас Англи хэлээр ажиллахгүй байх тул тус асуудлыг шаардлагад нийцэх эсэхийг хяна үзэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Иймд дээрх Сангийн яамны шийдвэрийн дагуу үнэлгээний хороо хуралдаж хуралд оролцогч тус бүр өөрийн утас болон компьютероос (e-invest.mn) цахим хуудсанд нэвтэрч цахим хуудас ажиллаж буй эсэхийг туршин үзэж, ажиллаж байгааг баталсан тул “Эверест солюшн” ХХК-ийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан гэж үзэж гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хүргүүлсэн. Шалгарсан		

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					байгууллагатай Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас хөгжүүлэх ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн ЦХХХЯ/20240103037 дугаар гэрээг байгуулж, ажлын даалгаварт заасан ажлыг бүрэн гүйцэтгүүлэн 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж, цахим хуудсыг хүлээн авсан. 6. Их өгөгдлийн (big data) сан үүсгэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох судалгаа ЦХХХЯ/20240203034 дугаартай 70,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг харьцуулалтын аргаар 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зарлаж, “ШУТИС-Мэдээлэл, холбооны Технологийн сургууль” (40,000,000 төгрөг), “Систем центр” ХХК (67,000,000 төгрөг) буюу нийт 2 оролцогчтойгоор 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10:30 цагт нээсэн. Тендерт оролцогчдыг үнэлгээний хороо хянан үзэхэд “Систем центр” ХХК-ийн төслийн удирдагчаар санал болгосон албан хаагч Батбаатарын Баасандорж нь ШУТИС-МХТС-ын Мэдээллийн сүлжээний Бакалаврын зэрэгтэй байгаа нь Мэдээллийн технологи, өгөгдлийн шинжлэх ухаан эсхүл математик-статистикийн салбарт дээд боловсрол эзэмшсэн, магистрын зэрэгтэй гэх шаардлагыг хангахгүй, ТШББ-ын үйлчилгээ үзүүлэх хуваарь буюу Маягт 6-ын дагуу ирүүлээгүй, ШУТИС-Мэдээлэл, Холбооны Технологийн сургууль сургууль-ийн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тодорхойлолт ирүүлээгүй, Нийгмийн даатгалын тодорхойлолт татах боломжгүй, Монголын татварын албаны тодорхойлолтоор үлдэгдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан ерөнхий шаардлага магадлах шаардлагыг хангаагүй гэж, мөн Сүүлийн		


Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					3 жилийн санхүүгийн тайлан ирүүлээгүй нь Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.2-т Сүүлийн 3 жилийн аль нэг жилийн орлого төсөвт өртгийн 50%-иас дээш байх шаардлагыг хангаагүй тул бүх тендерээс татгалзах тухай мэдэгдлийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлж, тендер амжилтгүй болсон.Тус тендерийг харьцуулалтын аргаар дахин 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зарлаж, “Софт ассист” ХХК (60,000,000 төгрөг), “Ай Ти инсайт” ХХК (62,001,495 төгрөг) буюу нийт 2 оролцогчтойгоор 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 10:30 цагт нээсэн. Тендерт оролцогчдыг үнэлгээний хороо хянан үзэхэд үнийн өсөх дарааллаар эрэмбэлэхэд эхэнд эрэмбэлэгдсэн оролцогч “Софт ассист” ХХК тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан тул гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлсэн. Шалгарсан байгууллагатай Их өгөгдлийн (big data) сан үүсгэхэд хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн ЦХХХЯ/20240203034 дугаар гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллага гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгэж тайланг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн бөгөөд гэрээ дүгнэсэн акт үйлдэн ажиллаж байна.		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох	Олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо	-	1	Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг /Койка/-ын буцалтгүй тусламжаар Монгол Улсад хэрэгжүүлж буй төслүүдийг танилцуулах хуралд 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Зам, тээврийн яаманд тус яамыг төлөөлж оролцсон.	2024.01.10- 2024.12.05	100%
2.	Арга хэмжээ 2. Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох	Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо	-	1	1.“Хиймэл оюун ухааны хэрэглээ, хэрэгжилт, цаашдын чиг хандлага” сэдвээр 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Мэдээллийн технологийн үндэсний парк дээр мэдлэг хуваалцах семинарт оролцсон. 2.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10” цахим мэдээлэл-сургалтад тогтмол хамрагдсан. 3.Шангри-Ла зочид буудалд 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан “EdTECH” хиймэл оюун ухааны арга хэмжээнд оролцсон. 4.Гадаад харилцааны яамны зөвшилцөл танхимд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Миний эрүүл мэнд, Миний эрх, Миний ирээдүй” залуучуудын уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон. 5.Шангри-Ла зочид буудалд 2024 оны 04 дүгээр сарын 08-аас 09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Төрийн бүтээмжийн сэргэлт “Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцсон.	2024.01.10- 2024.12.05	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

 / Г.Далайцэрэн /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)